



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 31 өдөр

Дугаар 6/19

Ховд

Ч.Түмэндэмбэрэлийг түр орлон гүйцэтгэгчээр  
томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.8, 43 дугаар зүйлийн 43.3.2, 43.4 дахь заалтууд, Засгийн газрын 2019 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга Г.Цэдэнбал нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн хуулийн дагуу чөлөөлөгдөх хүсэлтээ ирүүлж, ажлаас чөлөөлөгдсөн тул тус газрын Спорт дасгалжуулалтын албаны дарга Ч.Түмэндэмбэрэлийг 2020 оны 08 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн Биеийн тамир, спортын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2. Ч.Түмэндэмбэрэлд албан тушаалын үндсэн цалингаас 40 хувийн нэмэгдэл тооцож олгохыг аймгийн Биеийн тамир, спортын газрын нягтлан бодогч /О.Пүрэвсүх/-д зөвшөөрсүгэй.


3. Ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг хавсралтаар баталж, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга /Б.Ганболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2020 оны  
07 дугаар сарын 31-ний өдрийн  
Б/19 дүгээр захирамжийн хавсралт



**АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ  
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: Д.Энхболд - Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд: Ч.Сүхбаатар - Аймгийн Биеийн тамир, спортын газрын захиргаа, аж ахуйн албаны дарга

О.Пүрэвсүх - Аймгийн Биеийн тамир, спортын газрын нягтлан бодогч

М.Бадамцэцэг - Аймгийн Аймгийн Биеийн тамир, спортын газрын нярав

Нарийн бичгийн дарга: Ж.Батбаяр - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

-оОо-